

**АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.09.12

№ 18

Алтай хот

№	Хэлэлцэх асуудал	Хэн хэлэлцүүлэх	Хэн байлцах	Гарах шийдвэр
1	Хороо Байгуулах тухай	В.Рэнцэндорж		Тогтоол 73
2	Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай	П.Баасан	Ажлын хэсгийнхэн	Тогтоол 74
3	Дахин дуудлага худалдаа явуулах тухай	Л.Ганхуяг	З.Мөнхнасан Р.Пүрэвдорж	Тогтоол 75
4	Худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлт оруулж, хөрөнгө худалдах тухай	Л.Ганхуяг	З.Мөнхнасан Р.Пүрэвдорж	Тогтоол 76
5	Хөрөнгө акталж, данснаас хасахыг зөвшөөрөх тухай	Л.Ганхуяг	З.Мөнхнасан Р.Пүрэвдорж	Тогтоол 77
6	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Л.Ганхуяг	З.Мөнхнасан Р.Пүрэвдорж	Тогтоол 78
7	Ой тэмдэглэх тухай	Б.Баярсайхан	Ш.Цоодол	Тогтоол 79
8	Итгэмжлэгдсэн төлөөлөгч сонгох тухай	Л.Батжаргал		

**ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
АЖЛЫН АЛБА**



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 73

Есөнбулаг сум

Хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “ж” дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:


1. Засагт хан аймаг байгуулагдсаны 462, Хантайшир уулын аймаг байгуулагдсаны 97 жил, Говь-Алтай аймаг үүсгэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтсан ажлын бэлтгэл зохион байгуулалт хангах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ойг угтсан ажлын төлөвлөгөө боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 09-р сарын 12-ны өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт



АЙМГИЙН ОЙН УГТСАН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ,
БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Хорооны дарга: Аймгийн Засаг дарга
- Дэд дарга: Аймгийн ИТХ-ын дарга
Аймгийн Нутгийн зөвлөлийн дарга
- Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын
Хөгжлийн бодлого хариуцсан орлогч дарга
Аймгийн Засаг даргын
Нийгмийн бодлого хариуцсан орлогч дарга

Гишүүд:

- Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга
- Аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга
- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид
- Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга
- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
- Цэргийн штабын дарга, хурандаа
- Сумдын ИТХ-ын дарга нар
- Сумдын Засаг дарга нар
- Алтай хотын захирагч
- Шүүхийн тамгын газрын дарга
- Мэргэжлийн хяналтын газрын дарга
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Боловсрол, соёл урлагийн газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Онцгой байдлын газрын дарга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
- Биеийн тамир, спортын газрын дарга
- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга
- Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Тагнуулын хэлтсийн дарга
- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
- Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга
- "Нийтлэг үйлчилгээ" –ОНҮГ-ын дарга
- Алтай Улиастайн Эрчим хүчний систем ТӨХК-ийн захирал
- "Алтай" нисэх буудлын дарга
- "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын дарга
- Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
 - Аймгийн бөхийн холбооны тэргүүн
 - Аймгийн морин спорт уяачдын холбооны тэргүүн
 - Аймгийн сурын холбооны тэргүүн
 - Аймгийн шагайн холбооны тэргүүн
 - Аймаг дахь ТББ-ын тэргүүн



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 74

Есөнбулаг сум

Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг "Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 223 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам", Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан "Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар тус аймгийн Есөнбулаг сумд баригдсан 7 963 099 317 /Долоон тэрбум есөн зуун жаран гурван сая ерөн есөн мянга гурван зуун арван долоон / төгрөгийн үнэ бүхий Солонго хорооллын 120 айлын орон сууцны 2 блок барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэн авахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газрын дарга (Л.Ганхуяг) нарт зөвшөөрсүгэй.

2. Түрээсийн орон сууцны ашигтай талбайн үнэлгээг 1 400 000 төгрөгөөр, автомашины гражийг 10 000 000 төгрөгөөр тооцож, зорилтот бүлгийн иргэдэд түрээсийн хэлбэрээр өмчлүүлэх ажлыг зохион байгуулж, Хөгжлийн банканд төлөгдөх зээлийн хүүгийн төлбөр болох 1 435 684 993 төгрөгийг улс орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс төлж барагдуулахыг аймгийн Засаг даргад даалгасугай.

3. Алтай хотын Солонго хороололд баригдсан 120 айлын орон сууцыг зорилтот бүлгийн иргэдэд түрээсийн хэлбэрээр өмчлүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

4. Түрээсийн орон сууцны борлуулалтын асуудлыг хариуцах аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах асуудлыг судалж шуурхай шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), орон нутгийн өмчийн газрын дарга (Л.Ганхуяг) нарт даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 75

Есөнбулаг сум

**Дахин дуудлагын худалдаа
явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоол, 2017 оны 303 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 93 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Хувьчлах хөрөнгийн жагсаалтад хувьчлахаар батлагдсан боловч нээлттэй болон дахин дуудлагын худалдаагаар худалдан авах санал ирээгүй хавсралтад дурдсан 2 барилга байгууламжийн өмнө тогтоосон үнийн дүнг 50 хувиар бууруулж, 2 ачааны автомашины үнийг эзэмшигч байгууллагын саналыг үндэслэн тогтоосон үнээр дахин дуудлагын худалдааг явуулахыг зөвшөөрсүгэй.

2. Хувьчлагдаж буй өмч хөрөнгийг хувьчлагдах хүртэл хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, дахин дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) нарт тус тус даалгасгай.

ДАРГА Л.Батжаргал Л.БАТЖАРГАЛ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
20¹⁹ оны 09 дүгээр сарын 12-ны
өдрийн 75 дугаар тогтоолын хавсралт



50 ХУВЬ БУУРУУЛАН ХУВЬЧЛАХ БАРИЛГА, АВТОМАШИНЫ ТАНИЛЦУУЛГА

/ төгрөгөөр /

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Барилгын нийт талбай /м ² /	Ашиглалта нд орсон он	Ашигласан жил	Тоо хэмжээ	Анхны өртөг	Бүгд үнэ	Элэгдэл	Засвар хөрөнгө оруулалт	Үлдэгдэл өртөг	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 23, 24 дүгээр тогтоолоор тогтоосон үнэ	Хувьчлахаар тогтоосон үнэ
Нэг. Барилга байгууламж												
1	Тонхил сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилга	743.4	1996	21	1	215,369,010	215,369,010	180,000,000		33,574,268	9,220,000	4,610,000
2	Бугат сумын Цагдаагийн хэсгийн хуучин кабоны барилга /Хуучин Эрүүл мэндийн төвийн барилгын залгаа/	48	2008	9	1	26,222,500	26,222,500	22,070,596		4,151,904	1,375,000	687,500
Нийт дүн						241,591,510	241,591,510	202,070,596		37,726,172	10,595,000	5,297,500
Хоёр. Автомашин												
Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Автомашин ы марк	Улсын дугаар	Ашиглалта нд орсон он	Ашигла сан жил	Гүйлт км	Тоо хэмжээ	Анхны өртөг	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 23, 24 дүгээр тогтоолоор тогтоосон үнэ	Хувьчлахаар тогтоосон үнэ
1	"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын автомашин	dongfeng	ГАА93-28	2014	5	46,960	1	42,655,000	7,820,083	34,834,917	34,834,917	5,000,000
2	"Гэгээн нуур цэвэр ус" ОНӨААТҮГ-ын автомашин	daewoo	ГАУ75-21	2014	5	83,160	1	37,565,000	5,713,000	31,852,000	31,852,000	8,000,000
Нийт дүн								80,220,000	13,533,083	66,686,917	66,686,917	13,000,000

700



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 76

Есөнбулаг сум

**Худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлт
өөрчлөлт оруулж, хөрөнгө худалдах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Худалдах хөрөнгийн жагсаалтад нэмэлтээр оруулж буй 2 авто тээврийн хэрэгслийн хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталж, худалдах доод үнийг тогтоон, худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу явуулж, өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж)-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ




Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
20.19 оны 19 дүгээр сарын 12-ны өдрийн
76 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт



**2019 онд орон нутгийн өмчөөс нэмж худалдах
хөрөнгийн жагсаалт**

д/д	Хувьчлах хөрөнгийн нэр	Барилга, автомашины тоо	Хувьчлах арга, хэлбэр
Нэг. Автомашин			
1	Бугат сумын Эрүүл мэндийн төвийн УАЗ-31512 маркын, ГAA03-94 улсын дугаартай автомашин	1	Эзэмшигчид нь
2	Шарга сумын Эрүүл мэндийн төвийн УАЗ-31512 маркын, ГAA22-88 улсын дугаартай автомашин	1	Эзэмшигчид нь

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 20¹⁹ оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн
 76 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт



2019 ОНД НЭМЖ ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ТАНИЛЦУУЛГА

/төгрөг/

Нэг. Автомашин												
д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Автомашины марк	Улсын дугаар	Ашиглалтад орсон он	Үйлдвэрл эгдсэн он	Гүйлт км	Тоо хэмжээ	Анхны өртөг	Элэгдэл	Үлдэгдэл өртөг	Орон нутгийн өмчийн газрын худалдах үнийн санал	ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлаас тогтоосон үнэ
1	Бугат сумын Эрүүл мэндийн төв	УАЗ-31512	ГAA03-94	2012	2012	184358	1	18,500,000	18,500,000	-	1,500,000	500,000
2	Шарга сумын Эрүүл мэндийн төв	УАЗ-31512	ГAA22-88	2010	2010	124615	1	18,000,000	18,000,000	-	2,000,000	1,500,000
Дүн							2	36,500,000	36,500,000		3,500,000	2,000,000
НИЙТ ДҮН								36,500,000	36,500,000		3,500,000	2,000,000

--- 000 ---

2019



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 77

Есөнбулаг сум

**Хөрөнгө акталж, данснаас хасахыг
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит Халиун сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэлтэй нийт 63.273.600 /Жаран гурван сая хоёр зуун далан гурван мянга зургаан зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хуучин барилгыг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Акталж, данс бүртгэлээс хасч буй барилгыг буулгаж, нураан газрыг чөлөөлөх, буулгасан барилгаас гарсан цаашид хоёрдогч түүхий эд болгон ашиглах боломжтой хөрөнгийг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор тоолж, хэрхэн шийдвэрлүүлэх, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хууль, журмын дагуу зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Л.БАТЖАРГАЛ





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 78

Есөнбулаг сум

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.2 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Худалдах хөрөнгийн 2019 оны жагсаалтад нэмэлтээр орж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 35 дугаар тогтоолоор нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар батлагдсан Эрүүл мэндийн газрын УАЗ фургон маркийн, ГАА 85-61 улсын дугаартай суудлын автомашиныг эзэмшигчид нь 1.000.000 /нэг сая/ төгрөгөөр худалдах болгож өөрчилсүгэй.

2. Хөрөнгө худалдан борлуулах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу явуулж, өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (В.Рэнцэндорж), Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА *Л.Батжаргал* Л.БАТЖАРГАЛ





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 79

Есөнбулаг сум

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Олон нийтийн "Алтай" радио үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг 2019 оны 10 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсугай.

2. Ойг тэмдэглэх ажлын хэсгийн хавсралтаар баталсугай.

3. "Алтай" радио үүсэн байгуулагдсаны 30 жилийн ойг угтаж бүтээлч ажил өрнүүлэн, зохион байгуулалтын өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Ганбат), Олон нийтийн Алтай радиогийн удирдлага нарт даалгасугай.



ДАРГА Ж. Ганбат Д. БАТЖАРГАЛ

2019 оны 09-р сарын 12-ны өдрийн
79 дүгээр тогтоолын хавсралт



**ОЙГ УГТСАН БЭЛТГЭЛ АЖИЛ ХАНГАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ганбат - Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Ш.Цоодол- ОН-ийн "Алтай" радиогийн редактор

Гишүүд:

А.Амарзаяа- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга

Б.Баярсайхан-ОН-ийн "Алтай" радиогийн захирал

Ч.Жаргалсайхан- Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ч.Дэлгэрмаа- МСНЭ-ийн "Алтай" салбарын тэргүүн

Ж.Дашдаваа- "Шадар туслагч" ХХК-ний зөвлөх

---oo0oo---